



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2024.07.19 № 494

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

- Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

011021391

## Дүгнэлт

Дорнод аймгийн Монгол ардын намын аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дорнод аймгийн Монгол ардын намын мөрийн хөтөлбөр гучин хуудас хавсаргав.

Хувийг: “Дорнод аймгийн Монгол ардын намын хороо”-нд

Хувийг: Дорнод аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 30 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Монгол Ардын Намын  
хорооны Тэргүүлэгчдийн хурлын  
2024 оны 07 дугаар сарын 17-ны  
өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт




**ДОРНОД АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС  
2024 ОНЫ ОРОН НУТГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**ДОРНОД АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН 2024-2028 ОНЫ**

**МӨРИЙН ХӨТӨЛБӨР /төсөл/**

<b>Нэг. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>	
	1.1 Эрүүл мэндийн салбар 1.1.1 Хүүхдийн эрүүл мэнд 1.1.2 Иргэний эрүүл мэнд, зөв дадал хэвшил, урьдчилан сэргийлэлт 1.1.3 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж 1.1.4 Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөгжил, нийгмийн хангамж
	1.2 Боловсролын салбар 1.2.1 Боловсролын сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлнэ. 1.2.2 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ 1.2.3 Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангана. 1.2.4 Бүх шатны сургалтын байгууллагын стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлж сургуулийн анги бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.
	1.3 Хүн ам, нийгмийн хамгаалал 1.3.1 Хүүхэд, гэр бүл 1.3.2 Оюутан, залуус 1.3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 1.3.4 Ахмад настан
	1.4 Соёл, урлагийн салбар
	1.5 Спорт, нийтийн биеийн тамир
<b>Хоёр</b>	<b>ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО</b>
	2.1 Хүнс, хөдөө аж ахуйн салбар 2.1.1 Шинэ хоршоо хөдөлгөөн 2.1.2 Хүнсний аюулгүй байдал 2.1.3 Мал аж ахуй, газар тариалан
	2.2 Аялал жуулчлал, үйлчилгээний салбар
	2.3 Эрдэс баялагын салбар
	2.4 Үйлдвэрлэл ба хувийн хэвшлийг дэмжих орон нутгийн бодлого
<b>Гурав</b>	<b>ХӨГЖЛИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГАА</b>
	3.1 Эдийн засгийн коридорыг түшиглэсэн боомт, тээвэр логистик
	3.2 Түүх, соёл, байгаль, хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлал
	3.3 Зүүн бүсийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх хамтын санаачилга
<b>Дөрөв</b>	<b>ОРОН НУТАГ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГО</b>
	4.1 Орон зайн төлөвлөлт ба дэд бүтцийн хөгжил



	4.2 Чойбалсан хотын хөгжил	
	4.3 Сумын хөгжил	
<b>Тав</b>	<b>УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БУУРУУЛАХ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НОГООН ХӨГЖЛИЙНБОДЛОГО</b>	
	5.1 Эко системийн тэнцвэрт байдлыг хангах	
	5.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	
<b>Зургаа</b>	<b>ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН БОДЛОГО</b>	
	6.1 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ	
	6.2 Орон нутаг дах төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа	
	6.3 Иргэдийн аюулгүй байдал-орчны хүртээмж	
	6.4 Гадаад харилцаа ба хамтын ажиллагаа	

## НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүний эрхийг дээдэлж, иргэдийн хамтын оролцоог салбарт бүрт эрхэмлэн ил тод байдлыг ханган хүний хөгжил, боловсрол, хүүхэд хамгаалал, эрүүл мэнд, соёл урлаг, спорт, гэр бүл, нийгмийн бүлгүүдийн оролцооны хөгжлийг тэгш хангаж ажиллана.

**1.1 Идэвхтэй амьдрал, зөв дадал хэвшилтэй иргэнийг төлөвшүүлэх ЭРҮҮЛ МЭНД-ийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог бүх түвшинд хөгжүүлнэ.**

### 1.1.1 Хүүхдийн эрүүл мэнд

- 1.1.1.1 Аймгийн “Хүүхдийн эмнэлэг”-ийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, хүүхдийн төрөлжсөн тусламж үйлчилгээг төрөлжүүлэн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.1.2 Өсвөр насныхны “Аз жаргал төв”-ийн үйл ажиллагааг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.1.3 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүүхдийн хоолойн архаг (ангина) өвчнийг эрт илрүүлэх, эмчлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.1.4 Зорилтот бүлгийн хүүхдүүдийг томуугийн вакцинд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.1.5 Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.1.1.6 Сумын эрүүл мэндийн төвүүдэд суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах үйлчилгээг хэрэгжүүлнэ.



### 1.1.2 Иргэний эрүүл мэнд, зөв дадал хэвшил, урьдчилан сэргийлэлт

- 1.1.2.1 “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулах” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.1.2.2 Сайн дурын дархлаажуулалтыг эрчимжүүлэх төсөл хэрэгжүүлнэ.
- 1.1.2.3 Ахмадын “Өдрийн сувилал”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.2.4 “Эрүүл оюутан” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.2.5 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрсдэлээс хамгаалах “Эрүүл эрчүүд, эмэгтэйчүүд” төсөл хэрэгжүүлнэ.
- 1.1.2.6 Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд хөтөлбөрийн хүрээнд Элэгний В вирусийн халдваргүй нярай, “Эхчүүдээ хайрлая” төслийг хэрэгжүүлнэ.
- 1.1.2.7 Эмэгтэйчүүдийн товлотт дархлаажуулалтыг үндэсний хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх, хөхний эрүүл мэндийг хамгаалах “Эрүүл эмэгтэй” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.2.8 Хөдөлгөөн эрүүл мэнд төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.1.2.9 Нийгмийн цогц тусламж үйлчилгээ /эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёл, ахуй үйлчилгээ үзүүлэх/ үзүүлнэ.

### 1.1.3 Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж

- 1.1.3.1 Аймгийн “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр” (2017-2026 он)-ийг хэрэгжүүлнэ.
- 1.1.3.2 Аймгийн “Эрүүл мэндийн бүс”-ийг төлөвлөлтийн дагуу үе шаттайгаар ашиглалтад оруулна.
- 1.1.3.3 Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3.4 Эмнэлэгүүдийн гадна тохижилтийг сайжруулж, эмнэлэгийн ногоон бүсийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3.5 Сүрьеэгийн эмнэлэгийн барилгыг барьж дуусган бүрэн ашиглалтад оруулна.
- 1.1.3.6 “Бүсийн оношлогоо эмчилгээний төв”-ийн үйл ажиллагаанд суурьлан зүүн бүсийн сургалт, судалгааны хүрээлэнг байгуулна.
- 1.1.3.7 “Анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг өргөжүүлэх нь” төслийг сумдын Эрүүл мэндийн төвүүдэд үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.1.3.8 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санд нэгдэж, эрүүл мэнд, эмнэлгийн мэдээллийг нарийн мэргэжлийн дараагийн шатны эмнэлгүүдтэй цахимаар солилцох тогтолцоог бүрэн хэрэгжүүлнэ.
- 1.1.3.9 Аймгийн эрсдэлтэй бүсэд яаралтай тусламж үйлчилгээг хүргэх, яаралтай тусламжийн цэгүүдийг байгуулна.

#### **1.1.4 Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хөгжил, нийгмийн хангамж**

- 1.1.4.1 Эрүүл мэндийн ажилтнуудыг ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын нөхцөлийг хөнгөвчлөх, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.1.4.2 "Эмчийн туслах төслийг хэрэгжүүлнэ.
- 1.1.4.3 "Эмчийн хөгжлийг дэмжих" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.1.4.4 "Би сувилагч" болзолт уралдааны төсөл болгон хэрэгжүүлнэ.

#### **1.2 Хүүхэд бүрийн хөгжил, хамгаалал, БОЛОВСРОЛ, тэгш оролцоог ханган, эцэг, эх, багш, иргэдийн хамтын нэгдлийг үүсгэн иргэн бүрийн хөгжлийг эрхэмлэнэ.**

##### **1.2.1 Боловсролын сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлнэ.**

- 1.2.1.1 Сургуулийн өмнөх боловсролын болон Ерөнхий боловсрол, Мэргэжлийн боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
- 1.2.1.2 Бага ангийн сурагчдын сурлагын хоцрогдолыг арилгах төсөл хэрэгжүүлнэ.
- 1.2.1.3 Насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж насанд хүрэгчид, ахмад настанд зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.1.4 Ерөнхий боловсролын сургуулийн цайны газрыг иж бүрэн шинэчилж, олон улсын стандартад нийцүүлнэ.
- 1.2.1.5 Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдүүдийн хоол, цайны чанар, хүртээмж, төрөл, шим тэжээлийг үе шаттай нэмэгдүүлэн нэг хүүхдэд ногдох зардлыг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 1.2.1.6 Ерөнхий боловсролын сургуулийн бүх хүүхдүүдийг "Үдийн цай" хөтөлбөрт хамруулж, хоол, цайны чанар, хүртээмж, төрөл, шим тэжээлийг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 1.2.1.7 Аймгийн төвөөс алслагдсан багуудад "Багийн бага сургууль" байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.2.1.8 "Монгол бичгээ сурья" төслийг хэрэгжүүлнэ.

##### **1.2.2 Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, төлөвшил, сургалтын чанарыг сайжруулна.**


- 1.2.2.1 "Хүн болох багаасаа" гадаад хэлний сургалтын төслийг хэрэгжүүлнэ.
- 1.2.2.2 ЭЭШ эрчимжүүлсэн сургалт, амжилт үзүүлсэн багш, сурагчдыг урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.2.3 "Байгалийн шинжлэх" төсөл хэрэгжүүлнэ.
- 1.2.2.4 "Сургууль, цэцэрлэгийн бүс" төслийг хэрэгжүүлнэ.



- 1.2.2.5 Ерөнхий боловсролын сурагчдад үндэсний өв соёл, түүх, зан заншил, уламжлал, байгаль дэлхий, эх орноо хайрлах, эх оронч үзлийг төвөлшүүлэх “Эх оронч хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.2.6 Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны барилгын гадна болон дотор орчны стандартыг сайжруулж, барилгуудыг үе шаттай шинэчлэж өргөтгөнө.
- 1.2.2.7 “Миний ирээдүйн мэргэжил” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.2.8 Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг сургуулийн орчинд болон цахим орчинд үе тэнгийн дээрэлхэлтгүй болгох “Миний найз” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.2.9 Сурагчдын хөгжих таатай орчин бүрдүүлэх “Манай анги” төслийг ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжүүлнэ.
- 1.2.2.10 Ерөнхий боловсролын сургуулиудад жишиг номын сан байгуулах “Миний номын өргөө” төслийг дэмжиж ажиллана.

### **1.2.3 Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмж, нийгмийн баталгааг хангана.**

- 1.2.3.1 Багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.”
- 1.2.3.2 Ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг дэмжих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 1.2.3.3 Багшийн туслах төслийг хэрэгжүүлнэ.
- 1.2.3.4 Төрийн албан хаагчдын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш нарыг бодлогоор дэмжин, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төсөл, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ
- 1.2.3.5 Багш хөгжлийн төвийг үргэлжлүүлэн байгуулна.
- 1.2.3.6 СӨБ болон ЕБС-ын багш нарын 30-аас доошгүй хувийг тэгш хамруулах боловсролын арга зүйд суралцуулна.
- 1.2.3.7 Зүүн бүсийн “Багшийн хөгжлийн ордон” байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 1.2.3.8 Багшийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, чадварлаг багшийн залгамж холбоог тасралтгүй үргэлжлүүлэх, тэргүүний багш нарыг дэмжих, “Багшийн амжилт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



### **1.2.4 Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлж сургуулийн анги бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.**

- 1.2.4.1 Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөж суудлын тоог нэмэгдүүлнэ.
- 1.2.4.2 Бүх шатны боловсролын байгууллагуудад шаардлагатай техник, тоног төхөөрөмж нийлүүлж, сургалт үйлдвэрлэлийн чадавхийг нэмэгдүүлнэ.
- 1.2.4.3 Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж,



- сургалтын байгууллагын орчны стандартыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчныг бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 1.2.4.4 Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бэлдэхэд бодлогоор дэмжин ажиллана.
- 1.2.4.5 Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын бие даан, бүтээлчээр хөгжих, төлөвших үйлийг дэмжих, сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, материаллаг болон виртуал орчин бүрдүүлэх зорилгоор кабинет, лабораторийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.2.4.6 Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр орон нутагт ажиллах хүний нөөцийг бэлтгэн, чадавхжуулах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.2.4.7 Зүүн бүсийн инновацийн төв байгуулна.

### 1.3 Хүн ам, нийгмийн хамгаалал

#### 1.3.1 Хүүхдийн тэгш хөгжил, хамгаалал

- 1.3.1.1 Зүүн бүсийн “Хүүхдийн хөгжлийн ордон” барих ажлыг эхлүүлнэ.
- 1.3.1.2 Хүүхэд хамгаалалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын, болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.
- 1.3.1.3 Хүүхэд хамгааллын “Миний хүүхэд” цахим арга хэмжээг эхлүүлнэ.
- 1.3.1.4 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдах насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулан “Жаргалтай ээж”, “Халамжтай аав” хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.3.1.5 “Хүн болох багаасаа” авъяас сургалтын төслийг хэрэгжүүлнэ.
- 1.3.1.6 “Хүүхэд эрдэнэ” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.1.7 Аймгийн төв болон сумдын сургуулийн орчинг бүрэн камержуулж, аюулгүй орчныг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.1.8 Аймгийн төв болон сумдад хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагчийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.3.1.9 Байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтнынхаа хүүхдүүдэд зориулан хичээлээ хийх, чөлөөт цагаа өнгөрөөх, амрах өрөө бүхий өдөр өнжүүлэх төвүүдийг байгуулахыг дэмжин ажиллана.
- 1.3.1.10 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудад эцэг, эх-хүүхэд-багшийн хамтын оролцоо, санаачилгыг эрхэмлэсэн бүтээлч ажлуудыг дэмжин урамшуулна.
- 1.3.1.11 Хүүхэд хамгаалалын багийн үйл ажиллагааг дэмжин, нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэж ажиллана.

1.3.1.12 Хүүхдийн тоглоомын талбай, нийтийн эзэмшлийн гудамжны хүүхдийн аюулгүй орчны стандартыг бүрдүүлэх, хяналтыг сайжруулна.

### **1.3.2 Гэр бүлийн хөгжил, оролцоог ханган, дэмжиж ажиллана.**

- 1.3.2.1 “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.2.2 “Угийн бичиг”-ээ хөтөлж, удмын түүх, ургийн хэлхээгээ мэддэг үндэсний уламжлалаар дамжуулан “Гэр бүл”-ийн үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
- 1.3.2.3 Зүүн бүсийн “Гэрлэх ёслолын ордон”-г шинээр барих ажлыг эхлүүлнэ.
- 1.3.2.4 “Залуу гэр бүл”-ийг дэмжих орон нутгийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.2.5 “Жендерийн тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 1.3.2.6 Хүчирхийлэлд өртсөн гэр бүл, хүүхдэд, залуучуудад, нийгмийн хамгаалал, эрх зүйн туслалцаа үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг үйл ажиллагаагаар тогтмол дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.2.7 Гэр бүлээрээ чөлөөт цагаа өнгөрүүлэх, амрах зориулалттай үйлчилгээний төв, амралтын баазуудыг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.2.8 Иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүдийг байгуулна.

### **1.3.3 Мэргэжлийн боловсон хүчин, оюутны хөгжил**

- 1.3.3.1 Бүс нутгийн хүний хөгжил, эдийн засаг, хөгжлийн урт хугацааны бодлогод тулгуурлан нарийн мэргэжлийн төрөлжсөн инженер, техник технологи, тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин, хөдөө аж ахуйн салбарын дагнасан Зүүн Бүсийн Их Сургуулийг байгуулна.
- 1.3.3.2 Зүүн бүсийн “Их сургуулиудын хотхон”-ны үйл ажиллагааг үе шаттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3.3.3 Дорнод аймаг дахь Политехникийн коллежийн сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэн эрдэм, шинжилгээ, судалгааны төвийг байгуулна.
- 1.3.3.4 Аймгийн Политехникийн коллежийн барилгыг өргөтгөнө.
- 1.3.3.5 Оюутны хөгжил, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл, шинэ нээлт, ололт амжилтийг дэмжин ажиллана.
- 1.3.3.6 Оюутнуудыг бүс болон улс, олон улсын уралдаан тэмцээнд оролцоход дэмжиж ажиллана.
- 1.3.3.7 Хүүхэд, залуучуудын цахим боловсролыг дэмжих, технологийн хөгжилтэй эн зэрэгцэн хөгжих, дэмжлэг үзүүлэх “ЮнителХаб” төвийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.3.3.8 “Оюутны хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.3.9 Оюутан солилцоо, соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа, туршлага судлах, ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.



**1.3.4 Ахмад настныг дэмжих, амьдарлын туршлагыг өвлүүлэх, хүндэтгэх, хамгаалах, хамтын хөгжлийг эрхэмлэн ажиллана.**

- 1.3.4.1 Аймаг, сумын ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.
- 1.3.4.2 “Ахмадын төв”-ийг бүрэн ашиглалтад оруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.4.3 “Ахмадын ачлал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4.4 Ахмадуудыг олон улсын соёл урлаг, спортын тэмцээн уралдаанд оролцоход дэмжиж ажиллана.
- 1.3.4.5 Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.3.4.6 Зүүн бүсийн ахмад настаны асрамжийн газрын барилгад өргөтгөл хийж, үйлчилгээний хүртээмж, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.4.7 Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг Чойбалсан хотод нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорьчуулж, үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 1.3.4.8 Судалгаанд үндэслэн халамж, үйлчилгээ нэн шаардлагатай ахмадуудад дэмжлэг тусламж дэмжлэг үзүүлэх “Ахмадаа халамжлая” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.4.9 Ахмадын өдрийн сувилалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**1.3.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлнэ.**

- 1.3.5.1 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.5.2 Эмч, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургалтуудад тогтмол хамруулж, ур чадвараа нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжин ажиллана.
- 1.3.5.3 Төрийн болон үйлчилгээний бүх төрлийн байгууллагуудаас тэгш, хүртээмжтэй үйлчилгээ авах дэд бүтцийг сайжруулах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3.5.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, спортын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлнэ.
- 1.3.5.5 Тэгш хамруулах боловсролыг нэмэгдүүлж, хүртээмжтэй орчныг нэмэгдүүлнэ.
- 1.3.5.6 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн аюулгүй зорчих нийтийн гудамж талбай, байрны орц, гэр хорооллын гудамж, авто замын орц гарц, нийтийн үйлчилгээний байгууллагын дотоод, гадаад орчинд стандартыг хэрэгжүүлэн ажиллана.
- 1.3.5.7 Төр, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, хүмүүнлэгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.3.5.8 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв”-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нэмэгдүүлнэ.

**1.4 Үндэсний бахархал, түүх, уламжлалт өв соёл, СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ нэмэгдүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, иргэдийн хамтын оролцоотой соёл урлагыг хөгжүүлнэ.**



- 1.4.1 Аймгийн “Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.2 Аймгийн шинэ музейн дотоод, гадаад тохижилтын ажлыг үе шаттай сайжруулна.
- 1.4.3 Сумдын соёлын төвийн барилгуудыг өргөтгөх, үе шаттай шинэчлэх, тохижилтыг сайжруулах, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 1.4.4 Хүүхэд, залуучуудын чөлөөт цагаа зөв боловсрон өнгөрүүлэх нөхцөлөөр хангаж “Кино театр” байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.4.5 Аймгийн төв Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд хүүхдийн парк, байгуулах ажлыг төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.4.6 Угсаатны урлаг соёлын “Алтан дөрөө”, “Алтаргана”, “Баргажин”, “Хатагин”, “Тоонот нютаг”, “Уламжлалт язгуур урлагын наадам”, “Эв модны наадам”, “Хэрлэнгийн үдэш” томоохон арга хэмжээг нийтийн урлаг соёлын хөгжил, эдийн засгийн соёлын үйлдвэрлэл, өв уламжлалыг хадгалан сэргээн хөгжүүлэх, аялал жуулчлалтай уялдуулан уламжлан хэрэгжүүлнэ.
- 1.4.7 Халхгол суманд аялал жуулчлалыг нэмэгдүүлэх чиглэлээр “Их бурхант” цогцолбор байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.4.8 Түүх соёлын үл хөдлөх, хөдлөх дурсгалын хадгалалт, хамгаалалтыг иргэдийн оролцоотой сайжруулах, соёлын биет болон биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах ажлыг шинжлэх ухааны байгууллага, судалгааны хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж, олон нийтэд таниулна.
- 1.4.9 “То вангийн өв соёлын өргөө” үйл ажиллагааг өргөжүүлэн Зүүн Монголын өв соёлыг судлах ажлыг эхлүүлнэ.
- 1.4.10 Орон нутаг судлалыг эрчимжүүлэн орон нутгийн музейн үзмэрийг баяжуулах, тохижилтыг сайжруулах, сургалт сурталчилгаа, аялал жуулчлалын зориулалтаар хөгжүүлнэ.
- 1.4.11 Сумын Соёлын төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэн “Хүний хөгжлийн төв” болгон иргэдийг чөлөөт цагаа эрүүл, зөв боловсон өнгөрүүлэх, хөгжих, суралцах боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.4.12 “Соёл урлагын шилдэг ажилтан” болзолт уралдааныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.4.13 Сэцэн хааны Язгуур урлагийн өргөө байгуулна.

**1.5 Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн идэвхи, амьдарлын хэв маяг, эрүүл зөв дадал хэвшлийг хэвшүүлэх, спортын төрлүүдийг нэмэгдүүлэх, багийн спортыг дэмжих, хөгжүүлэх нийтийн БИЕИЙН ТАМИРЫГ хөгжүүлнэ.**

- 1.5.1 Аймгийн “Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5.2 “Хүн болох багаасаа” Спорт төслийг хэрэгжүүлнэ.
- 1.5.3 Тамирчид бэлтгэл хийх, томоохон тэмцээн уралдаан зохион байгуулах боломжтой усан бассейн бүхий спорт цогцолборын барилгыг дуусгана.
- 1.5.4 Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшил, төрийн бус байгууллага, спортын холбоо, клубуудын хамтын түншлэлийг нэмэгдүүлнэ.



- 1.5.5 Өвлийн спортоор төрөлжин хичээллэх стандарт орчиныг бүрдүүлсэн байгууллага, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.
- 1.5.6 Хэрлэн голыг түшиглэн төр-хувийн хэвшлийн хамтын оролцоотойгоор өвлийн спортын бааз байгуулна.
- 1.5.7 Аймгийн хүүхдийн төлөө зөвлөл, эцэг эх, багшийн хамтын оролцоотойгоор спортын төрлүүдээр төрөлжүүлэн “Өсвөрийн шигшээ” баг бүрдүүлж, дэмжиж ажиллана.
- 1.5.8 Багийн спортоор хичээллэх хүүхэд залуучуудыг урамшуулан тогтвортой үйл ажиллагааг явуулж амжилт гаргаж байгаа спортын клубүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 1.5.9 Үндэсний спортыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.5.10 Бүс, Улс, Олон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлнэ.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО**

### **2.1 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР**

#### **2.1.2 Хүнсний аюулгүй байдал**

- 2.1.2.1 “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж, “Дорнод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн парк”-ыг байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
- 2.1.2.2 Нэмүү өртөг шингэсэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн хөгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд бодлогоор дэмжин ажиллана.
- 2.1.2.3 Орон нутгийн иргэдийн хүнсний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байгаа мах, гурилыг экспортод гаргахыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.2.4 Орон нутгийн иргэдийн хүнсний дотоодын хэрэгцээг хангах төмс, хүнсний ногоо, цагаан идээ, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 2.1.2.5 Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх усалгаатай газар тариаланг дэмжих төсөл хэрэгжүүлнэ.
- 2.1.2.6 Орон нутгийн үйлдвэрлэл, ажлын байрыг нэмэгдүүлж, хүн амын хүнсний ногооны хэрэглээний дотоодын хангамжийг өсгөх “Хүлэмж” төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.7 Хүн амын хүнсний ногооны хэрэглээний дотоодын хангамжийг тасралтгүй хангах, хүнсний бүтээгдэхүүнийг хадгалах “Мянган зоорь” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- 2.1.2.8 Орон нутгийн иргэдийн жимс, жимсгэний дотоодын хэрэгцээг хангах "Жимсний мод тариалъяа" төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.9 Стандартын шаардлага импортыг орлох хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн хуулийн этгээдийг бодлогоор дэмжих ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.1.2.10 Зөгийн балны үйлдвэрлэлийн чанарыг сайжруулах, брэндийг хөгжүүлэх, орц найрлага бүхий нэр төрлийг нэмэгдүүлэн экспортод гаргах ажлыг зохион байгуулна.
- 2.1.2.11 Сумдын нутаг дэвсгэр, зан заншлын онцлог бүхий байдлыг илэрхийлсэн хүнсний бүтээгдэхүүний брэндийг тодорхойлж, орон нутгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.1.2.12 Дорнод аймгийн хэмжээнд хүнсний ногоо, үр тарианы шинэ сорт, үрийн төрлийг нутагшуулах ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.1.2.13 Гэр хорооллын өрхүүдийг хашаандаа хүнсний ногоо тариалах тариалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр усалгааны системийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

## **2.1.2 Мал аж ахуй, газар тариалан**

### **Мал аж ахуй**

- 2.1.2.1 Малын үүлдэр, омог нэмэгдүүлэн баталгаажуулж, газар зүйн байршил авах ажлыг үр дүнтэйгээр зохион байгуулан ашиг шим бүхий мал аж ахуйг хөгжүүлж, хөдөө аж ахуйн салбарын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.2.2 Мал аж ахуйн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх бодлого баримтлан бэлчээрийн мал аж ахуйг хагас эрчимжсэн, эрчимжсэн мал аж ахуйд үе шаттай шилжүүлэх, байгаль орчинд хор хөнөөлгүй үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.1.2.3 Хилийн боомтуудыг түшиглэн мал аж ахуйн эрүүл бүсүүдийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 2.1.2.4 Аймгийн малын бэлчээр, хадлан тэжээлийн талаар баримтлах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.2.5 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг экспортод гаргах ажлыг зохион байгуулна.
- 2.1.2.6 Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн жижиг, дунд хөнгөн үйлдвэрийг хөгжүүлж, шинэ техник, технологи, инновацид тулгуурласан байгаль орчинд хор хөнөөлгүй, ногоон үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.2.7 Малжуулах төслийг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.2.8 Аймаг сум, багуудад малын өвс, тэжээлийн агуулах барих ажлыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.2.9 "Бэлчээр, хадлангийн талаар баримталж байгаа бодлого"-ыг орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.1.2.10 Малын бэлчээрийн усжуулалт, усалгааны шинэ технологийг нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.



- 2.1.2.11 Бэлчээрт хөнөөл учруулж байгаа аливаа мэрэгч амьтан болон бусад шалтгаант нөхцөлийг байгаль орчин болон хүнд халгүй арга технологиор бууруулна.
- 2.1.2.12 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, биологийн олон янзын байдалыг хамгаалах, орон нутагт хөдөө аж ахуйн хүнсний тогтолцооны чадавхийг сайжруулах “Экко-Фарм” төслийг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

#### **Мал эмнэлэгийн чиглэлээр**

- 2.1.2.13 Малын халдварт өвчин, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, малын өвчингүй эрүүл бүс төслийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.14 Мал эмнэлэг, малын эмчилгээ, сувилгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин ажиллана
- 2.1.2.15 Мал эмнэлгийн тоног төхөөрөмж, лабораторийн хүчин чадал, орчин нөхцөлийг үе шаттай сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.16 Зоонозын өвчин судлалын төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 2.1.2.17 Сумдын мал эмнэлийн тасаг болон хувийн мал эмнэлгүүдийн үйл ажиллагааны чанар хүртээмжийг нэмэгдүүлж, малын гоц халдварт өвчнийг бууруулах чиглэлээр дэвшилтэд технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжнэ.
- 2.1.2.18 Мал эмнэлгийн салбарт ажиллаж байгаа боловсон хүчинг бэлтгэх, дэмжих чиглэлээр төсөл арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.1.2.19 Мал эмнэлэгийн ажилтнуудыг мэргэшүүлэх, хүний нөөцийг нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.1.2.20 Малын гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бууруулах “Эрүүл мал” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.21 **Газар тариалан** Газар тариалан эрхлэгчдийн техник дундын парк байгуулж, тариалан эрхлэгчдийн хөдөлмөрийн хөнгөвчлөх бодлого хэрэгжүүлнэ.
- 2.1.2.22 Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.1.2.23 Атар газрыг тариалангийн газрын ангилалд шилжүүлэн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна.
- 2.1.2.24 Аймаг, орон нутгийн газар тариалангийн тариалалт, чанар, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2.25 Га талбайгаас хураан авах үр тарианы гарц, чанарыг нэмэгдүүлэн, сорт төрлийг нутагшуулж, усалгаатай газар тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 2.1.2.26 Үр тариа хадгалах стандартын шаардлага хангасан агуулахыг бүрэн ашиглалтад оруулна.

#### **2.1.3 Шинэ хоршоо хөдөлгөөн**

- 2.1.3.1 Малчдын хамтын хөдөлмөрийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, эрсдэлийг даван гарах “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг сумдад хэрэгжүүлнэ.
- 2.1.3.2 Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.
- 2.1.3.3 Орон нутаг дахь малын эмч, зоо-техникчдийг мэргэшүүлэн бэлтгэх тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.3.4 Малчдад тулгамдсан нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хамтын оролцоог хангах, шинэ санал санаачилгыг дэмжих, мал аж ахуйн салбарт гарч байгаа дэвшилтэт технологийг таниулах, хөдөлмөр хөнгөвчлөх, аливаа олон төрлийн эрсдэлээс хамгаалах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.1.3.5 Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолыг үндэслэн “Шинэ хоршоо” хөдөлгөөний хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, малчдыг хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.

## **2.2 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАР**

- 2.2.1 “Дорнод аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө-2030” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.
- 2.2.2 Халхгол суманд түүх соёлыг өвлүүлэн таниулах, сурталчилах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх чиглэлээр “Ялалт цогцолбор” байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.2.3 Олон улсын болон дотоодын стандартад нийцсэн зочлох үйлчилгээний стандарт хангасан байгууллагын тоо, чанар, хүртээмж болон хоногт хүлээн авах дотоод, гадаадын жуулчны тоог нэмэгдүүлэх чиглэлээр санаачилга гаргасан иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана
- 2.2.4 Орон нутаг дахь аялал жуулчлалын чиг баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн аялал жуулчлалын салбараас орлого олох боломжийг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана.
- 2.2.5 Хил дамнасан, хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх, чиглэлээр “Хилийн аялал жуулчлал”-хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.6 Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг байгаль орчинд ээлтэй стандартад нийцсэн эко ариун цэврийн байгууламжтай болоход бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.7 Сувилалын зориулалт бүхий нуур, булаг, рашаан түшиглэсэн стандартад нийцсэн сувилалын үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.2.8 Орон нутгийн онцлогт нийцсэн, байгаль орчинд ээлтэй, стандартын шаардлага хангасан, тогтвортой эко аялал жуулчлалын бааз байгуулах иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дамжиж ажиллана.



- 2.2.9 Улирлын онцлогт тохирсон аймгийн нэрэмжит эвент арга хэмжээг тогтмол зохион байгуулж, орон нутгийн иргэдийн зан заншил, өв уламжлалыг таниулах арга хэмжээг зохион байгуулна.
- 2.2.10 Олон улсын өндөр зэрэглэлийн сүлжээ зочид буудал, рестораны үйлчилгээг нэвтрүүлэх, шинээр стандартын шаардлага хангахуйц зочид буудал, рестораны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.
- 2.2.11 Жуулчдад зориулсан “Худалдааны төв”-ийг Чойбалсан хотод төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.12 Буйр нуурыг түшиглэн дөрвөн улирлын эко аялал жуулчлалыг хөгжүүлэн дотоод гадаадын жуулчид хүлээн авах хүчин чадал бүхий цогцолбор байгуул бодлогоор дэмжинэ.

### **2.3 ЭРДЭС БАЯЛАГИЙН САЛБАР**

- 2.3.1 Уул уурхайн ашиглалтын талбай, тээвэрлэлтийн замыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хамгаалах ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.3.2 Нөхөн сэргээлт дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн усыг дахин ашигладаг, байгалийн нөөц ашигласан төлбөр бүрэн төлдөг хариуцлагатай уул уурхайг хууль тогтоомжийн дагуу бодлогоор дэмжинэ.
- 2.3.3 Уул уурхай, газрын тосны төслүүдийн нөлөөлөлд өртөж байгаа бүс нутгийн иргэдийн эдийн засаг, амжиргааны түвшинг дээшлүүлж, орон нутгийн хөгжилд оруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх зохицуулалтыг бий болгоно.
- 2.3.4 Уул уурхай, газрын тосны үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг хүнсний болон ахуйн хэрэгцээний бараа, ажлын хувцас болон шаардлагатай бараа материал худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангуулан орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжийг давуу эрхтэйгээр оролцох боломж, нөхцөлөөр хангана.
- 2.3.5 Уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч буй иргэд малчдад малын өвс тэжээлийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### **2.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ БА ХУВИЙН ХЭВШЛИЙГ ДЭМЖИХ ОРОН НУТГИЙН БОДЛОГО**

- 2.4.1 Оёмол бүтээгдэхүүн хувцас үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж орон нутгийн уул уурхайн болон аж ахуйн нэгжүүдийн ажлын хувцасыг нийлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.
- 2.4.2 Аймгийн хэмжээнд бичил уул уурхай байгуулахгүй байх бодлогыг хэрэгжүүлнэ
- 2.4.3 Хөдөлмөр эрхлэлт ба хувийн хэвшлийг дэмжих орон нутгийн бодлого
- 2.4.4 Жижиг, дунд үйлдвэрлэл болон гарааны бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах байраар дад ах ажлыг ажлыг бодлогоор дэмжинэ.
- 2.4.5 Эмэгтэй бизнес эрхлэгчдийг орон нутгийн зүгээс бодлогоор дэмжиж ажиллана.

- 2.4.6 Мэргэжлийн холбоодын үйл ажиллагааг эрчимжүүлэх төр хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ
- 2.4.7 “Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааг өргөтгөн, салбарыг сумдад байгуулж, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжин чадавхижуулж шаардлагатай санхүүжилт, зээл олгох ажлыг хэрэгжүүлнэ.
- 2.4.8 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх “Хөдөлмөрийн бирж”-үүдийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.4.9 Сумдын ахуй үйлчилгээний төвийг байгуулж ажлын байр нэмэгдүүлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

## **ГУРАВ. ХӨГЖЛИЙН ТЭНЦВЭРИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХАМТЫН АЖИЛЛАГАА**

### **3.1 ЭДИЙН ЗАСГИЙН КОРИДОРЫГ ТҮШИГЛЭСЭН БООМТ, ТЭЭВЭР ЛОГИСТИК**

- 3.1.1 Евро-Азийн эдийн засгийн тээврийн коридорт холбогдох зүүн бүсийн босоо тэнхлэг Эрээнцав боомт – Чойбалсан - Хөөт - Бичигт боомт чиглэлийн 588 км төмөр замыг барина.
- 3.1.2 Ачаа тээврийн Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 232 км төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.
- 3.1.3 Зүүн хойд Азийн бүсийн орнуудыг Төв, Дундад Азийн болон Ойрх Дорнодын орнуудтай холбох Мянганы замын зүүн хэсэг Сүмбэр боомтоос Сүхбаатар аймгийн Түмэнцогт чиглэлийн 528 км авто замыг барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 3.1.4 Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх тохиромжтой байршлуудад үйл ажиллагаа эрхлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжиж ажиллана.
- 3.1.5 Хөнгөн үйлдвэрлэл технологийн парк байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- 3.1.6 Аймгийн Эрээнцав, Сүмбэр боомтуудын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэн эдийн засгийн бүсийн өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 3.1.7 Чойбалсан хотод “Зүүн бүсийн олон улсын тээвэр логистикийн төв”- хуурай боомтыг байгуулна.
- 3.1.8 Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх 50 км хатуу хучилттай авто замыг барьж дуусгаж, бүрэн ашиглалтад оруулна.

### **3.2 ТҮҮХ, СОЁЛ, БАЙГАЛЬ, ХИЛ ОРЧМЫН БОЛОН ХИЛ ДАМНАСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**

- 3.2.1 Зүүн бүсийн аялал жуулчлалын маршрутуудыг холбож, аялал жуулчлалын нэгдсэн цахим мэдээллийн төв байгуулан бүс нутгийн болон улс, олон улсын зэрэглэлтэй эвент арга хэмжээг хамтран зохион байгуулж дотоод гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 3.2.2 Чингис хааны өлгий нутаг, түүх, соёлын нөөц, экосистемд түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, аялал жуулчлалын тусгай



бүсийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулахад хамтран ажиллана.

- 3.2.3 Зүүн бүсийн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн спортын бааз байгуулна.
- 3.2.4 Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Бурхан Халдун, Буйр нуур, Алтан Овоо зэрэг түүхэн дурсгалт газруудыг холбосон аялал жуулчлалын дэд бүтцийг шинээр байгуулах бодлого чиглэлийг хэрэгжүүлж ажиллана
- 3.2.5 Хил дамнасан болон хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бүс нутгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

### **3.3 ЗҮҮН БҮСИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХАМТЫН САНААЧИЛГА**

- 3.3.1 “Шинэ талын зам” хамтын санаачилгыг Сүхбаатар аймагтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.3.2 Зүүн бүсийн түүхэн аялал жуулчлалын авто замын дэд бүтэц, зам харилцааг өргөжүүлэх, иргэдийн эдийн засгийн хүртээмжийн нэмэгдүүлэх “Зүүн бүсийн авто зам” хамтын санаачилгыг Хэнтий аймагтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.3.3 Зүүн бүсийн эрчим хүчний хүртээмжийг нэмэгдүүлэх “Зүүн бүсийн эрчим хүч” хамтын санаачилгыг Хэнтий аймагтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.3.4 Дээд боловсролын сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их сургуулийн хотхоныг Чойбалсан хотод “Их сургуулийн хотхон”-ыг түшиглэн байгуулна.
- 3.3.5 Зүүн бүсийн байгаль орчин тэнцвэрт байдлыг хангах, усны нөөцийн хомсдолыг бууруулах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, байгалийн гамшиг гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, гал түймрээс урьдчилан сэргийлэх, эх дэлхийгээ хайрлан хамгаалах “Байгаль орчныг хамгаалах” хамтын санаачилгыг Хэнтий аймагтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.3.6 Зүүн бүсийн хүнсний сав баглаа боодлын үйлдвэрийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулах ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 3.3.7 Эм, эмнэлэгийн хэрэгслийг бүсийн хэмжээнд тогтвортой хүргэх зорилгоор
- 3.3.8 “Зүүн бүсийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулах”-ыг байгуулна.
- 3.3.9 Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэн салбар дундын дадлагын баазыг байгуулна.

### **ДӨРӨВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ-ТӨЛӨВЛӨЛТ**


#### **4.1 ЧОЙБАЛСАН ХОТЫН ТӨЛӨВЛӨЛТ-БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ**

- 4.1.1 Чойбалсан хотын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу Шинэ суурьшлын бүс, үйлдвэрийн бүсийг дулаан, цахилгааны эрчим хүчээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

- 4.1.2 Төр хувийн хэвшлийн түншлэлээр “Шинэ-Чойбалсан” суурьшилын бүс 1800 айлын орон сууцны хороолол барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.3 Бага дунд орлоготой иргэдийг орон сууцжуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.4 Хотын иргэдийн амрах ая тухтай орчин, чөлөөт цагийг өнгөрөөх орчыг нэмэгдүүлэн “Эргийн ландшафт”-ийн дагуу 2 байршилд цэцэрлэгт гудамж байгуулна /Хэрлэн сум 7, 6 дугаар баг/
- 4.1.5 МУИС-ийн Зүүн бүсийн сургуулийн шинэ хотхоны ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг төслийн дагуу барилгажилтын ажлыг эхлүүлнэ.
- 4.1.6 Чойбалсан хотын төв “Ивээл хороолол”-ын дахин төлөвлөлтийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- 4.1.7 Монгол Улсын Засгийн газрын “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.1.8 Залуу гэр бүлийг дэмжих, төрийн байгууллагад нэн шаардлагатай мэргэжлээр ажиллаж байгаа албан хаагчдад зориулсан “Миний анхны орон сууц” төслийг хэрэгжүүлнэ.
- 4.1.9 Хуучны ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцуудад дахин төлөвлөлт хийж шинэ орон сууц барих ажлыг хэрэгжүүлнэ
- 4.1.10 Аймгийн төвийн авто зам, явган зам, дугуйн зам болон нийтийн эзэмшлийн хатуу хучилттай зам талбай, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх “Шинэ Чойбалсан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.1.11 Аймгийн төв болон сумдын төвийг бүрэн камержуулах ажлыг хэрэгжүүлнэ
- 4.1.12 Чойбалсан хотын хог хаягдал ангилан ялгаж боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна
- 4.1.13 Нийтийн эзэмшлийн талбайд “Боловсон ариун цэврийн байгууламж” барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.14 Энгийн хог хаягдлыг татан төвлөрүүлэх ажлыг зарим багуудад төр хувийн хэвшлийн түшлэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.15 Нийтийн эзэмшлийн гудамж талбайг арчлах ажлын менежментийг сайжруулж, тохижилт үйлчилгээний болон хог тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит байгууллагуудад тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.16 Аймгийн хэмжээнд угсармал болон тоосгон орон сууцны барилгуудыг хүчитгэн дулаалж, гадна орчныг сайжруулах ажлыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.

#### **Инженерийн шугам сүлжээ**

- 4.1.17 Чойбалсан хотын усан хангамжийн найдвартай байдлыг хангах зорилгоор гүний усны нөөц худгийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.1.18 Чойбалсан хотын усан хангамжийн эх үүсвэр болох “Төмөр шүүх станц”-ыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.1.19 Чойбалсан хотын ус хангамжийн шугам сүлжээний шинэчлэлийг бүрэн хийж дуусгана
- 4.1.20 Дулааны магистраль шугамыг өргөтгөх шинэчлэлийн ажлыг дуусгана.





- 4.1.21 Гэр хорооллыг дулаан, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх ажлыг үргэлжүүлнэ /Хэрлэн сумын 1 баг Силкат хороолол,4,8,10, 11 дүгээр баг/
- 4.1.22 Үүрэн холбооны сүлжээг өргөтгөх ажлыг сумдад хэрэгжүүлнэ.
- 4.1.23 Аймгийн төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэн барих ажлыг дуусгана.
- 4.1.24 Хэрлэн сумын 8 дугаар багт байрлах бохирын өргөх станцыг өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.25 Чойбалсан хотын бохир усны шугамуудыг үе шаттай шинэчилнэ.
- 4.1.26 Орон сууцны байрны цэвэр усны шугамын оруулгад ус цэвэршүүлэгч суурьлуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.27 Чойбалсан хотын зам, замын байгууламж дахь ус зайлуулах болон цуглуулах байгууламжийг дахин төлөвлөн шинэчлэх ажлыг эхлүүлнэ.
- 4.1.28 Сумын төвүүдийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэгдсэн халаалтад бүрэн холбож, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үе шаттай эхлүүлнэ.

#### **Авто зам, замын байгууламж**

- 4.1.29 Чойбалсан хотын босоо, хэвтээ тэнхлэгийн авто зам, замын байгууламж, авто зогсоолыг шинэчлэх шинээр барих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 4.1.30 Сумдыг аймгийн төвтэй хатуу хучилттай авто замаар холбох, сумдын төвүүдэд авто зам, байгууламжийг шинээр барих ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 4.1.31 Хэрлэн сумын 2,3,4,10,11 дүгээр багийн гэр хорооллын хойд талаар хэвтээ тэнхлэгийн 4 дүгээр тойрог замыг шинээр төлөвлөн барих ажлыг эхлүүлнэ.
- 4.1.32 Чойбалсан хотод стандартын шаардлага хангасан цахилгаан автомашины зогсоолыг бий болгоно.
- 4.1.33 Иргэд, олон нийтийн дугуйгаар зорчих, дугуйн спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн стандартын шаардлага хангасан дугуй замуудыг үе шаттай байгуулна.
- 4.1.34 Өндөр хаан-Чойбалсан А0502 чиглэлийн 50, 27 км авто замыг шинэчлэн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.1.35 Чойбалсан хотоос Хавирга хилийн боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто замын барьж дуусгана.
- 4.1.36 Босоо тэнхлэгийн авто замыг шинэчлэх ажлыг эхлүүлнэ.
- 4.1.37 Чойбалсан хотын Хэрлэн голын "Ялалт /зүүн цемэнтэн гүүр/-ийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ
- 4.1.38 Баян-Уул сумаас Чойбалсан хот хүртэл 200 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ.
- 4.1.39 Чойбалсан хот-Баянхошуу боомт чиглэлийн 220 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ
- 4.1.40 Хэрлэн голын дунд "Модон гүүр"-ийг төмөр бетон гүүр болгон шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.

4.1.41 Чойбалсан хотын энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг хүртэлх хатуу хучилттай авто замаар холбох ажлыг эхлүүлнэ.

### **Эрчим хүч**

4.1.42 Монгол Улсын Засгийн газрын Эрчим хүчний салбарын бодлогын шинэчлэлийг орон нутагт хэрэгжүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана.

4.1.43 Багануур-Өндөр-Хаан-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг эхлүүлнэ.

4.1.44 Томоохон Уул уурхайн төслүүдийг найдвартай эрчим хүчний сүлжээнд холбох ажлыг эрчимжүүлнэ.

4.1.45 Аймгийн хэмжээнд цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэх, өргөтгөх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.46 Эрчим хүчний салбарт инноваци, технологийг нэвтрүүлж сэргээгдэх эрчим хүчний парк байгуулах чиглэлээр санаачилга гаргасан хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжиж ажиллана.

4.1.47 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг хангах зорилгоор үйлдвэр үйлчилгээний суурьшлийн бүсүүдэд цахилгаан дамжуулах агаарын шугам шинээр татах, өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ.

### **Агаарын болон төмөр замын чиглэлээр**

4.1.48 “Чойбалсан” олон улсын нисэх буудлыг 4С ангиллын нисэх буудал болгон өргөтгөх ажлыг эхлүүлнэ.

4.1.49 Зүүн бүсийн босоо тэнхлэг Эрээнцав боомт Чойбалсан Хеет-Бичигт боомт чиглэлийн 588 км төмөр замыг барих ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

4.1.50 Улс, орон нутгийн дотоодын нислэгийн төрөл, давтамж, чиглэлийг нэмэгдүүлэх, үнийг тогтвортой байлгах бодлогыг баримтлан ажиллана.

4.1.51 Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон гуравдагч улстай олон улсын агаарын тээврийн маршруттай болох санал, хүсэлтийг холбогдох эрх бүхий байгууллагад уламжилж, шийдвэрлүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.1.52 Халхгол, Баяндун суманд нисэх онгоцны буудлыг байгуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

4.1.53 “Зүүн бүсийн олон улсын тээвэр логистикийн төв” хуурай боомтыг байгуулах ажлыг эхлүүлнэ

## **4.2 СУМЫН ХӨГЖИЛ БА НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ**

4.2.1 Хэрлэн сум

### **Нэгдүгээр баг**



- 4.2.1.1 Авто зам засвар, гэрэлтүүлэгийг шинэчлэн хүүхдийн тоглоомын талбай шинээр байгуулна.
- 4.2.1.2 Орон сууцны 28,50 дугаар байрны инженерийн шугам сүлжээг шинэчлэн, 50 дугаар байрны дээврийг засварлах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.3 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Ягаан цээнэ ӨЭМТ-ийг тоног төхөөрөмжөөр ханган тохижуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.4 Бунхан толгойг сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.5 Хүүхдийн автобусыг нэмэгдүүлнэ.
- 4.2.1.6 Хуучин төв хогийн цэгийг дарж булшлах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 4.2.1.7 Силкат хороололын инженерийн шугам сүлжээг шинээр тавих ажлыг дуусгана.

#### **Хоёрдугаар баг**


- 4.2.1.8 Хан-Уул цогцолбор сургуулийн бага сургуулийн барилгыг шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ
- 4.2.1.9 Хэрлэн сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгад өргөтгөл шинэчлэл хийнэ.
- 4.2.1.10 Хэрлэн голыг түшиглэн чийрэгжүүлэлтийн талбай байгуулна.
- 4.2.1.11 Багийн ажлын албаны байр барих ажлыг хэрэгжүүлнэ.

#### **Гуравдугаар баг**

- 4.2.1.12 Төр хувийн хэвшлийн түншлэлээр хүүхдийн парк байгуулах ажлыг хэрэгжүүлнэ
- 4.2.1.13 Танк,Түргэн,Бат-Уул,Овоот хэсгийн айл өрхийн дундуур гэрэлтүүлэг
- 4.2.1.14 Овоот хороололын хойд хэсгээр ЦДА шугамыг өргөтгөнө.
- 4.2.1.15 Бага сургуулийн барилгыг ашиглалтад оруулна
- 4.2.1.16 Багийн ажлын албаны байрны барилгыг засварлах ажлыг хэрэгжүүлнэ
- 4.2.1.17 Мянган жаргалан ӨЭМТ-ийн салбарын барилгыг инженерийн шугам сүлжээнд холбоно.
- 4.2.1.18 Түргэн хороололын инженерийн шугам сүлжээг өргөтгөнө

#### **Дөрөвдүгээр баг**

- 4.2.1.19 Зангиат хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.
- 4.2.1.20 Гэр хорооллын хог хаягдлын менежмент хэрэгжүүлэн хоггүй баг төсөл хэрэгжүүлнэ.
- 4.2.1.21 Гэр хорооллын гудамж төслийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ
- 4.2.1.22 Ахмадын чөлөөт цагийн танхимтай болно.
- 4.2.1.23 ТМС-ийн шар байр, багшийн коллежийн 5, 6, 7 дугаар байр, 45, 46 дугаар байрны дээврийн засвар, дулааны болон цэвэр, бохир усны шугамыг засварлах ажлыг хэрэгжүүлнэ.



4.2.1.24 Гэр хорооллын алслагдсан хэсэг дээр цахилгааны эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор дулааны шугамын дэд станц байгуулна.

#### **Тавдугаар баг**

4.2.1.25 Аймгийн төвөөс нэгдсэн хогны цэг хүртэлх авто зам шинээр барих ажлыг эхлүүлнэ.

4.2.1.26 Хүүхдийн тоглоомын талбай болон ахмадын чөлөөт цагаа өнгөрүүлэх төв барих ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.1.27 Үүрэн холбооны сүлжээг өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ

4.2.1.28 Өгөөмөр хороололыг ЦДА-ын шугамыг шинэчлэн эрчим хүчний найдвартай байдлыг хангана.

#### **Зургадугаар баг**

4.2.1.29 Ивээл болон Буйр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулна.

4.2.1.30 Уурхайн байрны гадна фасадыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.1.31 Хэрлэн сумын 5 дугаар сургуулийн барилгын инженерийн шугам сүлжээг шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.1.32 Хүүхэд багачуудын чөлөөт цаг өнгөрөөх тоглоомын талбайг үе шаттайгаар байгуулна

#### **Долоодугаар баг**

4.2.1.33 Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнд чийрэгжүүлэлтийн спорт талбай байгуулна.

4.2.1.34 Ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

4.2.1.35 Орон сууцны байруудад камержуулалт, гэрэлтүүлэг бүхий авто зам, дугуйн зам барих ажлыг дуусгана.

4.2.1.36 Тусгаар тогтнолын талбайн тохижилт, засварын ажлыг хийнэ.

#### **Наймдугаар баг**

4.2.1.37 Гэр хорооллын дунд хүүхдийн тоглоомын талбай байгуулна.

4.2.1.38 Цэвэр усны төвлөрсөн шугамыг шинэчлэн холбох ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.1.39 Орон сууцны 56,57,58 дугаар байрны гадна фасадыг засварлах ажлыг хэрэгжүүлнэ

4.2.1.40 Гэр хороололыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлэх

4.2.1.41 Гэр хорооллын эгнээ гудамжийг "Жишиг гудамж" болгон тохижуулах ажлыг хэрэгжүүлнэ

#### **Есдүгээр баг**

4.2.1.42 Хүүхдийн парктар болно.

4.2.1.43 Ахмадын ордонтой болно.



- 4.2.1.44 Хүүхдийн зуслантай болно.
- 4.2.1.45 Орон сууцны 1-17 дугаар байрны гадаах фасад дулаалга, дээврийн засварын ажлыг хийнэ.
- 4.2.1.46 Орон сууцны гадна зогсоолыг нэмэгдүүлж, камержуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.47 Найрамдал паркийн нийтийн ариун цэврийн байгууламжийг төвлөрсөн шугам сүлжээнд холбоно.

#### **Аравдугаар баг**

- 4.2.1.48 Ялалт хороололд хүүхдийн цэцэрлэг шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.49 Гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ./Дулаан/
- 4.2.1.50 Хэрлэн сумын 4, 10-р багийн голын хатуу хучилттай авто замыг шинэчлэн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.51 Орон сууцны 26, 27-р байрны гадна дулаалга, фасадыг шинэчлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.52 Багийн ажлын албаны хойно гэрэлт гудамж байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.1.53 Ялалтын 16-17 дугаар эгнээний дунд жишиг гудамж байгуулна.

#### **Арваннэгдүгээр баг**

- 4.2.1.54 Хивсний хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг эхлүүлнэ.
- 4.2.1.55 Ахмадын чөлөөт цагийн танхимтай болно
- 4.2.1.56 Уурхайчин хорооллын нуурыг цэцэрлэгт хүрээлэн болгон тохижуулах ажлыг эхлүүлнэ
- 4.2.1.57 Ахуй үйлчилгээний төвтэй болгох ажлыг хэрэгжүүлнэ
- 4.2.1.58 Үерийн ус зайлуулах суваг, шуудуй шинэчлэн засварлана.

#### **4.2.2 Баяндун сум**

- 4.2.2.1 Ерөнхий боловсролын сургуулийн спорт заал барина.
- 4.2.2.2 Сумын төвийн ус зайлуулах суваг шуудуй шинээр төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 4.2.2.3 Айл өрхүүдийг төвлөрсөн халаалтанд холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.2.2.4 Угтамын рашаан сувилалыг дэд бүтцэд холбоно.
- 4.2.2.5 Алслагдсан нутаг дэвсгэрт үүрэн холбооны сүлжээг нэмэгдүүлнэ.
- 4.2.2.6 Хуурай сүүний үйлдвэрийг ашиглалтанд оруулна.
- 4.2.2.7 Мах махан бүтээгдэхүүн боловсруулах стандарт үйлдвэр байгуулна.
- 4.2.2.8 Сумын төв доторхи хатуу хучилттай авто замын ажлыг үргэлжлүүлнэ.

#### **4.2.3 Баянтүмэн сум**

- 4.2.3.1 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах хогын цэгийг хашаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.


- 4.2.3.2 Сумын төвд асфальтан хучилттай замыг үргэлжлүүлэн барина.
- 4.2.3.3 Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг өргөтгөн шинэчилнэ.
- 4.2.3.4 Сумын 2,3 дугаар багт үүрэн холбооны сүлжээг сайжруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.3.5 Сумын эмнэлгийг түшиглэн суурь өвчтэй хүүхдийг сувилан эрүүлжүүлэх сувилал байгуулна.
- 4.2.3.6 Спорт заал шинээр барина
- 4.2.3.7 Хөдөөгийн багуудад гэр цэцэрлэг, өдөр өнжүүлэх төвийг байгуулна.
- 4.2.3.8 Тахианы аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 4.2.3.9 Сүү боловсруулах цех байгуулна.

#### 4.2.4 Баян-Уул сум

- 4.2.4.1 Эрчим хүчний өргөтгөл, сумын төвийн авто замын гэрэлтүүлэг нэмэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.2 Сумын энгийн хог хаягдлыг дарж булшлах нүүлгэн шилжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.3 Цэцэрлэгийн өргөтгөл барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.4 Эмнэлгийн өргөтгөл барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.5 Сумын төв 4,5-р багт хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.6 Хуучин эмнэлэгийн барилгад засвар хийж, ахмадын сувилалын газар байгуулна.
- 4.2.4.7 Төрийн албан хаагчийн орон сууц барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.8 Буриад угсаатан зүйн үзмэрийг нэмэгдүүлнэ.

#### 4.2.5 Булган сум

- 4.2.5.1 Булган сумын төвийг Өндөрхаан –Чойбалсангын замтай хатуу хучилттай замаар холбох ажлыг эхлүүлнэ.
- 4.2.5.2 Сумын төвийн Иргэдэд үйлчлэх төвийн засварыг хийнэ.
- 4.2.5.3 Сургуулийн дотуур байрны барилгыг шинээр барина.
- 4.2.5.4 Туг-Чингисийн тахилгын сүм байгуулна.
- 4.2.5.5 Сумын төвийн гэрэлтүүлгийг сайжруулна.
- 4.2.5.6 Сумыг нэгдсэн халаалтад холбоно.
- 4.2.5.7 Ахуй үйлчилгээний төвийг засварлах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.5.8 Эрүүл мэндийн төвд их засвар хийнэ.



#### 4.2.6 Гурванзагал сум

- 4.2.6.1 Сумын төвийг нэгдсэн халаалтад холбоно.



- 4.2.6.2 Ариутгалын ДҮК машин авна
- 4.2.6.3 Энгийн хог хаягдал дахин боловсруулах, ангилах эко цех байгуулна.
- 4.2.6.4 Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шинэчлэн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 4.2.6.5 Сургуулийн барилгын фасад, дээврийг шинэчлэн засварлана.
- 4.2.6.6 Эрүүл мэндийн төвийн барилгыг барилгыг засварлана

#### **4.2.7 Дашбалбар сум**


- 4.2.7.1 Сумын иргэдийг эко орон сууцжуулах ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 4.2.7.2 Сумын төвд 5 км хатуу хучилттай авто зам барих ажлыг эхлүүлнэ
- 4.2.7.3 Хүүхдийн 240 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.7.4 Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.7.5 Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн дотуур байрны барилгад засвар шинэчлэл хийнэ
- 4.2.7.6 Буриад судлалын музейн үзэл баримтлал, үзүүллэг дэглэлтийн төлөвлөгөө боловсруулан дотоод тохижилт хийнэ.
- 4.2.7.7 ЕБС-ийн сургуулийн барилгад өргөтгөл хийнэ.
- 4.2.7.8 Сумын төвийн Аят, Дун, Дөрөө, Наанги, Овоот, Цагаан дэв хорооллуудад хүүхдийн тоглоомын талбай байгуулна.
- 4.2.7.9 Улааны орд уурхайгаас Дашбалбар сум хүртэлх 75 км авто замыг барих ажлыг эхлүүлнэ.

#### **4.2.8 Матад сум**

- 4.2.8.1 Сумын төвд хатуу хучилттай авто зам барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.8.2 Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөн шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.8.3 Сумын төвийг төвлөрсөн халаалтад холбоно.
- 4.2.8.4 Авто замын гэрэлтүүлэгийг нэмэгдүүлнэ.

#### **4.2.9 Сэргэлэн сум**

- 4.2.9.1 Сумын төвийг төвлөрсөн хаалтад холбож, цэвэр бохир усны шугам сүлжээнд холбоно.
- 4.2.9.2 Нутгийн удирдлагын барилгыг шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.9.3 Уламжлалт эмчилгээний аргаар ашигладаг “Сэнжит хад”-ыг тохижуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.9.4 Жишиг ахуй үйлчилгээний төв байгуулна.
- 4.2.9.5 Мод үржүүлгийн газрыг байгуулна.
- 4.2.9.6 Хүүхдийн дотуур байрны барилга шинээр барих ажлыг хэрэгжүүлнэ



4.2.9.7 Чойбалсан хотоос Сэргэлэн сум чиглэл хатуу хучилттай авто зам барих ТЭЗҮ зураг төсөв хийлгэнэ.

4.2.9.8 Спорт заалны барилга барих ажлыг хэрэгжүүлнэ.

#### 4.2.10 Халхгол сум

4.2.10.1 Хилийн Баянхошуу болон Сүмбэр рашаантын боомтын цогцолборыг шинээр барьж байгуулна.

4.2.10.2 Сумын төв, ХЦ-ийн 0198 дугаар ангийг холбосон хатуу хучилттай автозам барих ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.10.3 Хамардаваа, Ялалтын хөшөөний цогцолбор байгуулна.

4.2.10.4 Жижиг дунд үйлдвэрлэлийн барилгын засвар шинэчлэлийн ажлыг хийнэ.

4.2.10.5 ТАХ-ийн байрны засвар үйлчилгээ, хуучин спорт заал, урлаг заалыг чөлөөт цагийн төв болгон засварлана.

4.2.10.6 Энгийн хог хаягдлын цэг байгуулна

4.2.10.7 Чойбалсан хотоос Халхгол сум чиглэлийн хатуу хучилттай замыг барих ажлыг эхлүүлнэ.

4.2.10.8 Сумын төв, Ялалт баг болон гэр хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ.

#### 4.2.11 Хөлөнбуйр сум

4.2.11.1 Суманд үр тариа, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, үйлдвэрийн аргаар хорголжин, багсармал тэжээл бэлтгэх, төл, малын арьс элдэх, анхан шатны боловсруулалт хийх цех үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

4.2.11.2 Нутгийн захиргааны байгууллагын барилгыг шинээр барих ажлыг эхлүүлнэ.

4.2.11.3 Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хувийн тохилог орон сууц барих хотхон хорооллын газрыг олгож, инженерийн шугам сүлжээг байгуулах нөөц боломжийг судалж үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.


#### 4.2.12 Цагаан-Овоо сум

4.2.12.1 240 хүүхдийн багтаамжтай бага сургуулийн барилга барина.

4.2.12.2 150 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн өргөтгөл барина

4.2.12.3 Сумын төвийн гэр хорооллыг нэгдсэн халаалтад холбох ажлыг эхлүүлнэ.

4.2.12.4 Сумын төв замыг хатуу хучилттай замаар солих ажлыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.





- 4.2.12.5 Хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд айл өрхийг эко ариун цэврийн байгууламжтай болгох арга хэмжээг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 4.2.12.6 Малчдыг сумандаа тохилог амьдрах боломжийг бүрдүүлж орон сууцны хотхон барих ажлыг хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулна.
- 4.2.12.7 Малын тэжээл тариалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэн аж ахуй нэгжийг бодлогоор дэмжин ажиллана.кэлкз

#### 4.2.13 Чойбалсан сум

- 4.2.13.1 Маршал Х.Чойбалсангийн хүндэтгэлийн цогцолбор барина.
- 4.2.13.2 Нэгдсэн халаалт, цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.13.3 Сумын төвд нийтийн ариун цэврийн байгууламж барина.
- 4.2.13.4 Аймгийн төвөөс Хавирга боомтын чиглэлд явж байгаа замыг Чойбалсан сумтай холбох 8км-тай, зураг төсвийг хийлгэж, замын ажлыг эхлүүлнэ.
- 4.2.13.5 Эрүүл мэндийн төвийн барилгыг өргөтгөнө.
- 4.2.13.6 Спорт залны барилга барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.13.7 Хөдөөгийн багууд болон төвлөрсөн цэгт сувилалын газар байгуулна.

#### 4.2.14 Чулуунхороот сум

- 4.2.14.1 Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн дотуур байр барих ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.14.2 Хүн амын нягтаршил нэмэгдэж байгаатай холбогдуулан төмөр замын хэсэгт шинээр цэцэрлэг барьж ашиглалтанд оруулна.
- 4.2.14.3 Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөртэй уялдуулан сурагчийн хөгжлийг хангах зорилгоор сургуулийн орчинг цахим болгох ажлыг хэрэгжүүлнэ.
- 4.2.14.4 “Тэр бум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлэг, хүнсний ногоо тариалах иж бүрэн цогцолбор байгуулна.
- 4.2.14.5 Худаг уст цэгийн тоог нэмэгдүүлэх, тэжээл тарих үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 4.2.14.6 Сумын төвийн зүүн хэсэгт цахилгааны дамжуулах агаарын шугамыг өргөтгөх ажлыг хэрэгжүүлнэ.

**ТАВ. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БУУРУУЛАХ, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

#### **5.1 ЭКО СИСТЕМИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАХ**

- 5.1.1 Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулах, ногоон сэргэлтийн хөгжлийн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 5.1.2 Аймгийн сумдууд, төв суурин газар ногоон бүтээмжийг нэмэгдүүлэх, ногоон ирээдүйг хөгжүүлэх “Дорнодын ногоон бүс” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.1.3 Ойжуулалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэн, Хэрлэн, Улз, Онон голыг татамыг ойжуулах ажлыг олон улсын төсөлтэй хамтран хэрэгжүүлнэ
- 5.1.4 Байгаль орчныг хамгаалах, эх дэлхийгээ хайрлах эх оронч үзлийг төлөвшүүлэх “Нэг голын хүүхдүүд” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.1.5 Буйр нуур, гол нуурын эрэг орчмын элсний нүүдлийг зогсоох, цөлжилтийг сааруулах ажлыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.1.6 Ногоон байгууламжийн тоо, талбайг нэмэгдүүлж, өөрийн орчны тохижилтыг хөгжүүлж байгаа өрх, байгууллагыг урамшуулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.

## 5.2 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ

- 5.2.1 Байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөлийг судлан тогтоох ажлыг олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2.2 Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.2.3 Байгалийн дурсгалт газар, нөөц газар, орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтыг иргэд болон мэргэжлийн байгууллагуудын оролцоо, дэмжлэгтэйгээр сайжруулж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.
- 5.2.4 Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 5.2.5 Хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 5.2.6 Буйр нуур, гол нуурын эрэг орчмын элсний нүүдлийг зогсоох, цөлжилтийг сааруулах ажлыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.
- 5.2.7 Чойбалсан хот болон сумдын хог хаягдлын цэгүүдийг стандартад нийцсэн хог ангилан ялгах цуглуулах цэгийг байгуулна.
- 5.2.8 Мэргэжлийн бүлгүүдтэй хамтран ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ
- 5.2.9 Орчины болон хөрсний бохирдолыг бууруулан “Эко жорлон” төслийг хэрэгжүүлсэн иргэн аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин ажиллана.
- 5.2.10 **ЗУРГАА. ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН БОДЛОГО**

## 6.1 ИРГЭДЭД ОЙР ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1.1 Төрийн бүх шатны байгууллагуудын боловсон хүчний чадавхыг сайжруулж, туршлагатай ахмад мэргэжилтэн, зөвлөхүүдийн туршлагаас дунд болон залуу үедээ хуваалцах, зөвлөгөө өгөх боломжийг бий болгоно.



- 6.1.2 Төрийн үйл ажиллагааг хөнгөн шуурхай ил тод нээлттэй хүргэх ажлыг цахим e-office хэлбэрээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргэж, төрийн үйлчилгээний хурд, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 6.1.3 Төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 6.1.4 Иргэдэд шууд үйлчилгээ хүргэх чиг үүрэг бүхий байгууллагын албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадварт иргэд үнэлгээ өгөх нэгдсэн системийг нэвтрүүлнэ.
- 6.1.5 Хүн амын мэдээллийн технологийн боловсролын түвшинг дээшлүүлэх замаар олон нийтийн цахим хэрэглээг нэмэгдүүлнэ.
- 6.1.6 Цахим аюулгүй байдлыг хангах цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлнэ.

## **6.2 ОРОН НУТАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО БА НИЙГМИЙН БАТАЛГАА**

- 6.2.1 Хөдөө орон нутагт нэн шаардлагатай сул орон тоог нөхөх, тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчнийг бэлтгэх "Нутгийн ирээдүй" сургалтын төлбөрийн тэтгэлэгт төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.2.2 Улаанбаатар хотод суралцаж байгаа оюутан залуучуудыг сургуулиа төгсөөд аймаг, орон нутагтаа амьдрахад дэмжлэг үзүүлнэ.
- 6.2.3 Засаг захиргааны анхан шатны нэгж багийн хөгжлийг дэмжих ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, багийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.2.4 Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой байдлыг хангах хүрээнд Төрийн албан хаагчийн сургалт, хөгжил нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 6.2.5 Сумдад хэрэгжиж байгаа Төрийн албан хаагчдын "Нутгийн ирээдүй" орон сууц хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

## **6.3 ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ-ОРЧНЫ ХҮРТЭЭМЖ**

- 6.3.1 Иргэдийн аюулгүй, тайван амьдрах орчныг бүрдүүлэх үүднээс хотын гудамж, зам, талбай, олон нийтийн зорчих хэсэг, гэр хорооллын гудамжийг үе шаттайгаар бүрэн камержуулах, гэрэлтүүлэгтэй болгох ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.3.2 Аймгийн хэмжээнд "Теле хяналтын нэгдсэн төв" байгуулна.
- 6.3.3 Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр гадна тоглоомын талбайн техник, тоног төхөөрөмжийн стандартын шаардлагыг хангуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 6.3.4 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр хууль хяналтын байгууллагад дэмжлэг үзүүлнэ.
- 6.3.5 Агаар, хөрс, орчны бохирдлоос сэргийлэх ажлыг бодлогоор дэмжинэ.

## **6.4 ГАДААД ХАРИЛЦАА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- 6.4.1 Гуравдагч улс орнуудтай "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 6.4.2 Олон улсын байгууллага, тэдгээрийн хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүдтэй хамтын ажиллагааг идэвхжүүлж, шинээр төсөл хөтөлбөрт хамрагдах, орон нутагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.
- 6.4.3 Зүүн хойд Азийг хамарсан хөдөө аж ахуй, аялал жуулчлал, байгаль орчны чиглэлээр бүс нутгийн хэмжээнд нэгдсэн төслүүд хэрэгжүүлнэ.
- 6.4.4 Зүүн хойд Азийн Интеграцид нэгдэн, "Дорнын зам" төсөл хэрэгжүүлж худалдаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын форум, уулзалт, үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна.
- 6.4.5 ОХУ, БНХАУ-ын хөрш зэргэлдээ аймаг, хот, мужуудтай хилийн боомтыг түшиглэсэн Худалдааны чөлөөт бүс байгуулах чиглэлээр хамтран ажиллана.
- 6.4.6 Хөрш зэргэлдээ аймаг, хот, мужууд болон олон улсын байгууллагууд, Элчин сайдын яамд, Консулуудтай хамтран хөрөнгө оруулалт оруулах боломжийг судалж, хамтран ажиллана.
- 6.4.7 Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эдийн засаг, хөрөнгө оруулалтын форум, албан уулзалт, арга хэмжээг зохион байгуулна.

-\*\*\*-